



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/218,

Улаанбаатар хот

「 Хан-Уул дүүргийн 29 дүгээр цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,000,018.00 (нэг сая арван найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 29 дүгээр цэцэрлэг (А.Дэжидсүрэн)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 5 нэр төрлийн 1,000,018.00 (нэг сая арван найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Хан-Уул дүүргийн 29 дүгээр цэцэрлэг (А.Дэжидсүрэн)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцаа
ааргын 2024 оны 12 дугаар сарын
өдрийн 12.18 дугаар тушаал

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 29 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжээ хилийн хилийн	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	ҮХХХК-ын хурлын шийдвэр
1	Ширээ багш	10	ш	1	264,000.00	264,000.00	264,000.00	0.00	Эвдэрч муудсан	Актлах	0.00	Устгах
2	Ширээ багш	10	ш	1	192,918.00	192,918.00	192,918.00	0.00	Эвдэрч муудсан	Актлах	0.00	Устгах
3	Ширээ багш	10	ш	1	139,280.00	139,280.00	139,280.00	0.00	Эвдэрч муудсан	Актлах	0.00	Устгах
4	Ширээ багш	10	ш	1	264,000.00	264,000.00	264,000.00	0.00	Эвдэрч муудсан	Актлах	0.00	Устгах
5	Ширээ багш	10	ш	1	139,820.00	139,820.00	139,820.00	0.00	Эвдэрч муудсан	Актлах	0.00	Устгах
Тавилга, эд хогшлын дүн						1,000,018.00	1,000,018.00	0.00				
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						1,000,018.00	1,000,018.00	0.00				
Үүнээс: Хоёрдогч түүхий эдээр худалдах хөрөнгө						0.00	0.00	0.00				
Актлах хөрөнгө						1,000,018.00	1,000,018.00	0.00				
Татан төвлөрүүлэх хөрөнгө						0.00	0.00	0.00				
Худалдсанаас олох орлого						0.00	0.00	0.00				
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/						0.00	0.00	0.00				